

ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2026/008/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН СҮМБЭР СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН 2025  
ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН  
АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2026 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: [khishigjargalts@audit.gov.mn](mailto:khishigjargalts@audit.gov.mn)

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: [amarjargalo@audit.gov.mn](mailto:amarjargalo@audit.gov.mn)

Аудитор: Б.Адъяасүрэн

Утас: 70273204 Цахим хаяг: [adiyasuren@audit.gov.mn](mailto:adiyasuren@audit.gov.mn)

Гэрээгээр гүйцэтгэсэн:

Уваа уул аудит ХХК, захирал: Ч.Мөнхтуяа

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: [www.open.audit.mn](http://www.open.audit.mn)



**ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум  
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn  
Цахим хаяг: www.audit.mn

2025.02.25 № 01/169  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ТӨВ АЙМГИЙН СҮМБЭР  
СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН  
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  
Т.БАТ-ЭРДЭНЭ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Сүмбэр сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Сүмбэр сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Төв аймгийн орон нутгийн өмчийн газрын 2025 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн "Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох тухай" зөвшөөрлийн дагуу элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч цаашид ашиглах боломжтой 87,627.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг 61,393.8 мянган төгрөгөөр үнийг шинэчлэн тогтоосон байна.

**Аудитын гол асуудал**

Мед импекс интернэшнл ХХК-аас шүдний эмчилгээний 18,040.1 мянган төгрөгийн иж бүрэн сандлыг хандивлаж, үйл ажиллагаандаа ашиглаж байна.

**Бусад асуудлын хэсэг**

Тус байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилт бүхий нийт 34 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 94.4 хувиар үнэлэгдсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

4126020181

Төв аймгийн Сүмбэр сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны  
санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

Төв аймгийн Сүмбэр сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны  
санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>285,020,887.04</b>	<b>121,546,450.37</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>341,345.40</b>	<b>2,210.41</b>
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>341,345.40</b>	<b>2,210.41</b>
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	<b>341,345.40</b>	<b>2,210.41</b>
31211	Төрийн сангийн харилцах	341,345.40	2,210.41
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>195,138,206.34</b>	<b>1,025,032.44</b>
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	192,650,740.14	1,025,032.44
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	<b>2,487,466.20</b>	<b>-</b>
3351	Байгууллагаас авах авлага	2,487,466.20	-
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>89,541,335.30</b>	<b>120,519,207.52</b>
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>5,642,219.65</b>	<b>20,266,499.61</b>
35130	Эм боох материал	5,642,219.65	20,266,499.61
35300	Бэлэн бүтээгдэхүүн	17,481,734.59	18,496,954.19
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>66,417,381.06</b>	<b>81,755,753.72</b>
35410	Бичиг хэргийн материал	192,500.00	1,808,800.00
35420	Аж ахуйн материал	37,416,320.00	25,067,048.33
35430	Сэлбэг хэрэгсэл	605,000.00	605,000.00
35460	Хүнсний материал	1,339,725.00	739,975.00
35470	Бусад хангамжийн материал	26,863,836.06	53,534,930.39
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>449,293,424.48</b>	<b>557,163,186.90</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>449,293,424.48</b>	<b>557,163,186.90</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>446,417,424.48</b>	<b>553,847,186.90</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	395,158,082.90	455,269,722.90
39202	Хуримтлагдсан элэгдэл	(94,674,718.19)	(114,428,003.75)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	75,160,000.00	56,340,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(56,410,000.17)	(42,590,000.21)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	250,943,640.07	262,757,725.85
39206	Хуримтлагдсан элэгдэл	(140,106,600.60)	(85,696,970.34)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	37,225,028.86	38,212,931.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	(22,266,988.45)	(22,159,139.03)
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,376,480.00	6,208,080.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(130,412.94)	(210,073.02)
39217	Ном	142,913.00	142,913.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>2,876,000.00</b>	<b>3,316,000.00</b>
39301	Програм хангамж	550,000.00	440,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(550,000.00)	-
39303	Бусад биет бус хөрөнгө	2,876,000.00	2,876,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>734,314,311.52</b>	<b>678,709,637.27</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>7,441,631.08</b>	<b>6,730,321.11</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>7,441,631.08</b>	<b>6,730,321.11</b>
<b>413</b>	<b>Өглөг</b>	<b>7,441,631.08</b>	<b>6,730,321.11</b>

**Төв аймгийн Сүмбэр сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны  
санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

41310	Ажилчидтай холбогдсон өглөг	4,911,112.08	13,804.65
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	2,530,519.00	6,716,516.46
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>726,872,680.44</b>	<b>671,979,316.16</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>726,872,680.44</b>	<b>671,979,316.16</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	103,436,234.32	103,436,234.32
51101	Өмч: - төрийн	103,436,234.32	103,436,234.32
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>418,224,680.07</b>	<b>363,631,315.79</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	418,224,680.07	418,524,680.07
51220	Тайлант үеийн үр дүн	-	(54,893,364.28)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	205,211,766.05	204,911,766.05
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>734,314,311.52</b>	<b>678,709,637.27</b>

Төв аймгийн Сүмбэр сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны  
санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>992,606,841.01</b>	<b>990,193,812.59</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>57,466,666.45</b>	<b>170,501,514.88</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>57,466,666.45</b>	<b>170,501,514.88</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	57,466,666.45	19,520,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	19,520,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	57,466,666.45	00.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	00.00	139,533,909.16
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	00.00	11,447,605.72
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>935,140,174.56</b>	<b>819,692,297.71</b>
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>42,415,900.00</b>	<b>46,868,000.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	42,415,900.00	46,868,000.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>892,724,274.56</b>	<b>772,824,297.71</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	892,724,274.56	772,824,297.71
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>828,334,620.47</b>	<b>1,045,087,176.87</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>828,334,620.47</b>	<b>1,045,087,176.87</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>827,574,035.17</b>	<b>1,010,100,368.21</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>520,846,837.76</b>	<b>649,150,428.16</b>
210101	Үндсэн цалин	337,305,260.59	358,309,147.75
210102	Нэмэгдэл	141,114,225.94	216,537,587.28
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,506,000.00	11,243,300.36
210104	Урамшуулал	39,921,351.23	63,060,392.77
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>53,939,445.62</b>	<b>72,887,471.63</b>
210201	Тэтгэврийн даатгал	53,939,445.62	49,563,479.63
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	5,830,998.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	1,166,199.60
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	4,664,798.40
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	11,661,996.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>41,149,125.35</b>	<b>41,938,591.34</b>
210301	Гэрэл, цахилгаан	5,082,223.35	8,374,787.34
210302	Түлш, халаалт	34,981,056.00	33,166,304.00
210303	Цэвэр, бохир ус	1,085,846.00	397,500.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>44,992,170.51</b>	<b>46,783,200.72</b>
210401	Бичиг хэрэг	1,918,220.00	2,157,200.00
210402	Тээвэр, шатахуун	28,226,225.51	27,442,362.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,112,000.00	2,497,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,983,050.00	5,383,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,752,675.00	9,302,738.72
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>82,601,903.11</b>	<b>80,478,965.75</b>

**Төв аймгийн Сүмбэр сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны  
санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	67,074,473.11	63,981,264.75
210502	Хоол, хүнс	15,510,430.00	11,382,400.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	17,000.00	5,115,301.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>11,702,550.00</b>	<b>47,657,379.87</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,124,150.00	7,388,213.20
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	150,000.00
210604	Урсгал засвар	9,578,400.00	40,119,166.67
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>2,950,000.00</b>	<b>1,540,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	2,950,000.00	1,540,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>2,102,114.00</b>	<b>1,891,284.00</b>
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,080,000.00	1,008,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	625,050.00	549,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	212,064.00	127,864.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	00.00	93,600.00
210807	Газрын төлбөр	00.00	7,820.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	185,000.00	105,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	17,952,860.00	13,891,300.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	49,337,028.82	53,881,746.74
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>760,585.30</b>	<b>34,986,808.66</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>00.00</b>	<b>34,986,000.00</b>
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	16,986,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	18,000,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>760,585.30</b>	<b>808.66</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	760,585.30	808.66
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>164,272,220.54</b>	<b>(54,893,364.28)</b>
<b>145</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,633,320.00</b>	<b>00.00</b>
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	1,633,320.00	00.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>(1,633,320.00)</b>	<b>00.00</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>162,638,900.54</b>	<b>(54,893,364.28)</b>

Төв аймгийн Сүмбэр сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны  
санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	<b>753,712,260.42</b>	<b>1,030,838,005.41</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>711,296,360.42</b>	<b>19,520,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	-	19,520,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	19,520,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	19,520,000.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>711,296,360.42</b>	<b>964,450,005.41</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	711,296,360.42	964,450,005.41
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>42,415,900.00</b>	<b>46,868,000.00</b>
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>42,415,900.00</b>	<b>46,868,000.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	42,415,900.00	46,868,000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>764,644,035.55</b>	<b>1,003,847,900.40</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>764,644,035.55</b>	<b>1,003,847,900.40</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>763,883,450.25</b>	<b>966,861,091.74</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>504,503,879.74</b>	<b>646,259,976.20</b>
210101	Үндсэн цалин	269,891,556.55	358,309,147.75
210102	Нэмэгдэл	178,688,756.76	213,647,135.32
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,766,400.00	11,243,300.36
210104	Урамшуулал	52,157,166.43	63,060,392.77
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>64,699,720.46</b>	<b>78,675,231.02</b>
210201	Тэтгэврийн даатгал	41,936,720.46	52,139,631.02
210202	Тэтгэмжийн даатгал	4,965,100.00	5,901,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,915,100.00	5,879,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,952,600.00	2,950,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,930,200.00	11,803,300.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>40,498,532.56</b>	<b>41,868,000.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	4,017,477.40	6,188,471.34
210302	Түлш, халаалт	34,981,056.00	34,951,028.66
210303	Цэвэр, бохир ус	1,499,999.16	728,500.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>43,425,358.65</b>	<b>43,786,932.00</b>
210401	Бичиг хэрэг	1,414,220.00	3,393,000.00
210402	Тээвэр, шатахуун	27,873,399.65	26,350,937.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,947,500.00	2,257,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,140,500.00	5,206,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,049,739.00	6,578,995.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>71,921,596.20</b>	<b>71,432,766.18</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	51,404,591.20	54,985,372.18
210502	Хоол, хүнс	14,911,500.00	12,130,394.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,605,505.00	4,317,000.00

**Төв аймгийн Сүмбэр сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны  
санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>14,989,918.64</b>	<b>49,991,642.34</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,101,436.50	19,697,791.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,933,200.00	-
210604	Урсгал засвар	8,955,282.14	30,293,851.34
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>2,950,000.00</b>	<b>1,340,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	2,950,000.00	1,340,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>2,266,614.00</b>	<b>2,708,484.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	1,000,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,080,000.00	576,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	420,000.00	420,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	317,114.00	299,664.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	100,000.00	55,000.00
210807	Газрын төлбөр	-	7,820.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	349,500.00	350,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>18,627,830.00</b>	<b>30,798,060.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,627,830.00	30,798,060.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>760,585.30</b>	<b>36,986,808.66</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>-</b>	<b>36,986,000.00</b>
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	16,986,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	20,000,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>760,585.30</b>	<b>808.66</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	760,585.30	808.66
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>(10,931,775.13)</b>	<b>26,990,105.01</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>19,097,800.00</b>	<b>27,329,240.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>19,097,800.00</b>	<b>27,329,240.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>19,097,800.00</b>	<b>27,329,240.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	19,097,800.00	27,329,240.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(19,097,800.00)</b>	<b>(27,329,240.00)</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>(30,029,575.13)</b>	<b>(339,134.99)</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>30,370,920.53</b>	<b>341,345.40</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>341,345.40</b>	<b>2,210.41</b>

Төв аймгийн Сүмбэр сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны  
санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	103,436,234.32	205,211,766.05	259,046,317.65	567,694,318.02
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>103,436,234.32</b>	<b>205,211,766.05</b>	<b>259,046,317.65</b>	<b>567,694,318.02</b>
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	162,638,900.54	162,638,900.54
C08	<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>103,436,234.32</b>	<b>205,211,766.05</b>	<b>418,224,680.07</b>	<b>726,872,680.44</b>
D01	<b>2025 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл</b>	<b>103,436,234.32</b>	<b>205,211,766.05</b>	<b>418,224,680.07</b>	<b>726,872,680.44</b>
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	300,000.00	300,000.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>103,436,234.32</b>	<b>205,211,766.05</b>	<b>418,524,680.07</b>	<b>727,172,680.44</b>
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	(300,000.00)	00.00	(300,000.00)
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	954,893,364.28)	(54,893,364.28)
D09	<b>2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>103,436,234.32</b>	<b>204,911,766.05</b>	<b>363,631,315.79</b>	<b>671,979,316.16</b>

**Төв аймгийн Сүмбэр сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны  
санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Код	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,169,471,300.00</b>	<b>1,030,837,196.75</b>	<b>138,634,103.25</b>	<b>88.15</b>
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>46,868,000.00</b>	<b>46,867,191.34</b>	<b>808.66</b>	<b>100.00</b>
132001	Орон нутгийн төсвөөс	46,868,000.00	46,867,191.34	808.66	100.00
<b>1340</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,094,535,000.00</b>	<b>964,450,005.41</b>	<b>130,084,994.59</b>	<b>88.12</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,094,535,000.00	964,450,005.41	130,084,994.59	88.12
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>28,068,300.00</b>	<b>19,520,000.00</b>	<b>8,548,300.00</b>	<b>69.54</b>
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	28,068,300.00	19,520,000.00	8,548,300.00	69.54
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,169,471,300.00</b>	<b>1,031,176,331.74</b>	<b>138,294,968.26</b>	<b>88.17</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,169,471,300.00</b>	<b>1,031,176,331.74</b>	<b>138,294,968.26</b>	<b>88.17</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,124,403,300.00</b>	<b>994,190,331.74</b>	<b>130,212,968.26</b>	<b>88.42</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>694,651,400.00</b>	<b>646,259,976.20</b>	<b>48,391,423.80</b>	<b>93.03</b>
210101	Үндсэн цалин	448,992,400.00	358,309,147.75	90,683,252.25	79.80
210102	Нэмэгдэл	166,659,000.00	213,647,135.32	(46,988,135.32)	128.19
210103	Унаа хоолны хөнгөлөлт	15,000,000.00	11,243,300.36	3,756,699.64	74.96
210104	Урамшуулал	64,000,000.00	63,060,392.77	939,607.23	98.53
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>90,744,100.00</b>	<b>78,675,231.02</b>	<b>12,068,868.98</b>	<b>86.70</b>
210201	Тэтгэврийн даатгал	59,139,300.00	52,139,631.02	6,999,668.98	88.16
210202	Тэтгэмжийн даатгал	7,062,200.00	5,901,700.00	1,160,500.00	83.57
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,887,200.00	5,879,800.00	1,007,400.00	85.37
210204	Ажилгүйдлийн даатгал	3,531,100.00	2,950,800.00	580,300.00	83.57
210205	Эрүүл мэндийн даатгал	14,124,300.00	11,803,300.00	2,321,000.00	83.57
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>41,868,000.00</b>	<b>41,868,000.00</b>	<b>-</b>	<b>100.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	6,779,200.00	6,188,471.34	590,728.66	91.29
210302	Түлш, халаалт	34,988,800.00	34,951,028.66	37,771.34	99.89
210303	Цэвэр, бохир ус	100,000.00	728,500.00	(628,500.00)	728.50
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>74,158,900.00</b>	<b>48,710,932.00</b>	<b>25,447,968.00</b>	<b>65.68</b>
210401	Бичиг хэрэг	6,234,200.00	3,393,000.00	2,841,200.00	54.43
210402	Тээвэр, шатахуун	44,460,100.00	26,350,937.00	18,109,163.00	59.27
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,464,600.00	2,257,200.00	1,207,400.00	65.15
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	7,000,000.00	5,206,800.00	1,793,200.00	74.38
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13,000,000.00	11,502,995.00	1,497,005.00	88.48
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>101,274,000.00</b>	<b>71,432,766.18</b>	<b>29,841,233.82</b>	<b>70.53</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	66,000,000.00	54,985,372.18	11,014,627.82	83.31
210502	Хоол, хүнс	27,774,000.00	12,130,394.00	15,643,606.00	43.68

**Төв аймгийн Сүмбэр сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны  
санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	7,500,000.00	4,317,000.00	3,183,000.00	57.56
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>84,431,000.00</b>	<b>72,036,882.34</b>	<b>12,394,117.66</b>	<b>85.32</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	29,311,000.00	22,037,691.00	7,273,309.00	75.19
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	5,120,000.00	-	5,120,000.00	-
210604	Урсгал засвар	50,000,000.00	49,999,191.34	808.66	100.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>3,000,000.00</b>	<b>1,340,000.00</b>	<b>1,660,000.00</b>	<b>44.67</b>
210702	Дотоод албан томилолт	3,000,000.00	1,340,000.00	1,660,000.00	44.67
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>3,066,000.00</b>	<b>2,708,484.00</b>	<b>357,516.00</b>	<b>88.34</b>
210801	БГБН ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,000,000.00	1,000,000.00	-	100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	576,000.00	576,000.00	-	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	420,000.00	420,000.00	-	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	420,000.00	299,664.00	120,336.00	71.35
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	100,000.00	55,000.00	45,000.00	55.00
210807	Газрын төлбөр	200,000.00	7,820.00	192,180.00	3.91
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	350,000.00	350,000.00	-	100.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>31,209,900.00</b>	<b>31,158,060.00</b>	<b>51,840.00</b>	<b>99.83</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	31,209,900.00	31,158,060.00	51,840.00	99.83
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>45,068,000.00</b>	<b>36,986,000.00</b>	<b>8,082,000.00</b>	<b>82.07</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>45,068,000.00</b>	<b>36,986,000.00</b>	<b>8,082,000.00</b>	<b>82.07</b>
213208	Хөдөө орон нутаг тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	25,068,000.00	16,986,000.00	8,082,000.00	67.76
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	20,000,000.00	20,000,000.00	-	100.00
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>341,345.40</b>		
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>2,210.41</b>		

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой 932,443.2 мянган төгрөгийн алдаа илэрснийг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав. Үүнд:

Санхүүгийн байдлын тайланд 38,221.3 мянган төгрөгийн байгууллагад төлөх өглөг, бусад зардлын тооцооны өглөг дансны хасах дүнтэйгээр илэрхийлсэн.

Санхүүгийн үр дүнгийн тайланд Эрүүл мэндийн газраас олгосон 2,862.6 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө дансанд бүртгээгүй.

Туслах үйл ажиллагааны орлого 2,534.0 мянган төгрөгийг засгийн газрын нөөц хөрөнгийн санхүүжилтээр, 16,986.0 мянган төгрөгийг урсгал үйл ажиллагааны санхүүжилт (орон нутгаас) дансанд тайлагнасан.

Цалин, хөлс болон нэмэгдэл урамшлын зардал, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл, эрүүл мэндийн даатгалын зардал үр дүнгийн тайланд 2,897.4 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.

Өмчийн өөрчлөлтийн тайлангийн өмнөх оны үзүүлэлтийг тэг дүнтэй илэрхийлсэн.

Санхүүгийн үр дүнгийн тайланд бараа материал акталсан 22,192.2 мянган төгрөгийн зардлыг дутуу илэрхийлсэн.

Эргэлтийн эмийн сангаас шилжин ирсэн үндсэн хөрөнгийг үлдэгдэл өртгөөр бүртгэж тайлагнаагүй.

Эрүүл мэндийн төвийн барилгад тайлант онд хийсэн 24,478.8 мянган төгрөгийн урсгал засварын зардлыг үндсэн хөрөнгийн сайжруулалтаар бүртгэсэн.

Ориентплюс ХХК-аар эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилгын зургийг 19,000.0 мянган төгрөгөөр хийлгэж, бүртгэлд тусгаагүй, шууд зардалд тайлагнасан.

Батлагдсан бүтэц орон тооны дагуу ажиллаж байгаа ажилтны ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн төрлөөр бүртгээгүй. Үр дүнгийн тайланд гүйлгээний тайлангийн Эрүүл мэндийн даатгал (210205) дансанд нийт дүнгээр 72,887.4 мянган төгрөгөөр бүртгэснийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 “аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланг үндэслэн залруулах бөгөөд зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна”, 15.2 “нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэж тус тус заасны дагуу санхүүгийн тайланд залруулга хийсэн.

Аудитаар нийт 3,562.4 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 2,255.4 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 1,306.7 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өглөө.

Аудитаар илэрсэн 3,562.4 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 8,317.9 мянган төгрөгөөс бага байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

### 5.2 Албан шаардлага

1.Тайлант оны эцэст 6,670.3 мянган төгрөгийн өглөгтэй тайлагнасан харилцагч байгууллагуудтай өр төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасантай нийцээгүй байна.

Төв аймгийн Сүмбэр сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны  
санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Шийдвэрлэсэн: Харилцагч байгууллагуудтай тооцоо нийлж зөрчлийг арилгах албан шаардлага өгөв.

2. Шатахууны зарцуулалтын тайлан, жолоочийн тооцооны хуудасны бүртгэл бүрэн хөтлөөгүй, тооцоо бодоогүйгээр нийт 2,255.4 мянган төгрөгийн шатахуун илүү зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-т "хариуцлагатай байх", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай тус тус нийцээгүй.

Шийдвэрлэсэн: Шатахууны зарцуулалтын тайлан, жолоочийн тооцооны хуудасны бүртгэл бүрэн хөтлөх, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөв.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Санхүүгийн тайлантай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалын дагуу Санхүүгийн тайлангийн мэдээлэл агуулсан тодруулга тайлан бэлтгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна", 8.1.5-д "Санхүүгийн тайлангийн тодруулга", Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/3 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын 8.3-д "Санхүүгийн тайлангийн тодруулга нь Санхүүгийн байдлын тайлан, санхүүгийн үр дүнгийн тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланд толилуулаагүй боловч тэдгээрийн аль нэгийг ойлгоход хамааралтай нэмэлт мэдээллээр хангана" гэж заасантай тус тус нийцэхгүй, "иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн тайланг тайлбар тодруулгын хамт бэлтгэж байх зөвлөмж өгөв.

#### 2. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Байгууллагын үндсэн үйл ажиллагаанд ашиглагдаж буй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 71 ширхэг 41,785.7 мянган төгрөгийн хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоогоогүй, өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны "Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох" тухай 271 дүгээр тогтоолын 7.1-д "төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ", Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-д "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна

Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгөнд тавих хяналтыг сайжруулж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоох саналыг Төв аймгийн Орон нутгийн өмчийн газарт хүргүүлж, шийдвэрлүүлэх.

### **3. Зардлын данстай холбоотой асуудал**

#### Илрүүлэлт:

Тайлант онд хоолны зардлаас 1,306.7 мянган төгрөгийн тээвэр шатахууны худалдан авсан.

Энэ нь Төвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Сангийн сайдын 2021 оны “Төсвийн ангилал шинэчлэн батлах тухай” 190 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилалд ашиглах заавар”-тай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Зардлын эдийн засгийн ангилал ашиглах зааврын дагуу гүйлгээ хийх

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 10-ний өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Төв аймгийн Сүмбэр сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны  
санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

*/мянган төгрөгөөр/*

д/д	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
								Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Санхүүгийн байдлын тайланд 38,221.3 мянган төгрөгийн байгууллагад төлөх өглөг, бусад зардлын тооцооны өглөг дансны хасах дүнтэйгээр илэрхийлсэн.	1	38,221.3			1	38,221.3	1	38,221.3		
2	Санхүүгийн үр дүнгийн тайланд Эрүүл мэндийн газраас олгосон 2,862.6 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө дансанд бүртгээгүй.	1	2,862.6			1	2,862.6	1	2,862.6		
3	Туслах үйл ажиллагааны орлого 2,534.0 мянган төгрөгийг засгийн газрын нөөц хөрөнгийн санхүүжилтээр, 16,986.0 мянган төгрөгийг урсгал үйл ажиллагааны санхүүжилт (орон нутгаас) дансанд тайлагнасан.	1	19,520.0			1	19,520.0	1	19,520.0		
4	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшлын зардал, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл, эрүүл мэндийн даатгалын зардал үр дүнгийн тайланд 2,897.4 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.	1	2,897.3			1	2,897.3	1	2,897.3		
5	Өмчийн өөрчлөлтийн тайлангийн өмнөх оны үзүүлэлтийг тэг дүнтэй илэрхийлсэн.	1	726,872.7	1	726,872.7			1	726,872.7		
6	Санхүүгийн үр дүнгийн тайланд бараа материал акталсан 22,192.2 мянган төгрөгийн зардлыг дутуу илэрхийлсэн.	1	22,192.2	1	22,192.2			1	22,192.2		
7	Эргэлтийн эмийн сангаас шилжин ирсэн 3,510.7 үндсэн хөрөнгийг үлдэгдэл өртгөөр бүртгэж тайлагнаагүй.	1	3,510.7			1	3,510.7	1	3,510.7		

Төв аймгийн Сүмбэр сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны  
санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

8	Эрүүл мэндийн төвийн барилгад тайлант онд хийсэн 24,478.8 мянган төгрөгийн урсгал засварын зардлыг үндсэн хөрөнгийн сайжруулалтаар бүртгэсэн.	1	24,478.8			1	24,478.8	1	24,478.8		
9	“Ориентплюс” ХХК-аар эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилгын зургийг 19,000.0 мянган төгрөгөөр хийлгэж, бүртгэлд тусгаагүй, шууд зардалд тайлагнасан.	1	19,000.0			1	19,000.0	1	19,000.0		
10	Батлагдсан бүтэц орон тооны дагуу ажиллаж байгаа ажилтны ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн төрлөөр бүртгээгүй. Үр дүнгийн тайланд гүйлгээний тайлангийн Эрүүл мэндийн даатгал (210205) дансанд нийт дүнгээр 72,887.4 мянган төгрөгөөр бүртгэсэн.	1	72,887.5			1	72,887.5	1	72,887.5		
<b>Дүн</b>		<b>10</b>	<b>932,443.2</b>	<b>2</b>	<b>749,064.9</b>	<b>8</b>	<b>183,378.3</b>	<b>10</b>	<b>932,443.2</b>		

Төв аймгийн Сүмбэр сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны  
санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Д/д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс											
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
1	Шатахууны зарцуулалтын тайлан, жолоочийн тооцооны хуудасны бүртгэл бүрэн хөтлөөгүй, тооцоо бодоогүйгээр нийт 2,255.4 мянган төгрөгийн шатахуун илүү зарцуулсан байна.	1	2,255.4			1	2,255.4								
2	Тайлант оны эцэст 6,670.3 мянган төгрөгийн өглөгтэй тайлагнасан харилцагч байгууллагуудтай өр төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй.	1	-			1	-								
3	Тайлант онд хоолны зардлаас 1,306.7 мянган төгрөгийн тээвэр шатахууны худалдан авсан.	1	1,306.7					1	1,306.7						
4	Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалын дагуу Санхүүгийн тайлангийн мэдээлэл агуулсан тодруулга тайлан бэлтгээгүй байна.	1						1							
5	Байгууллагын үндсэн үйл ажиллагаанд ашиглагдаж буй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 71 ширхэг 41,785.7 мянган төгрөгийн хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоогоогүй, өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.	1						1							
	<b>Дүн</b>	<b>5</b>	<b>3,562.1</b>			<b>2</b>	<b>2,255.4</b>	<b>3</b>	<b>1,306.7</b>						

Төв аймгийн Сүмбэр сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны  
санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>								
Төв аймгийн Сүмбэр сумын Эрүүл мэндийн төвийн шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгахад нийт 171 мэдээлэл байршуулахаас хугацаандаа мэдээлсэн 144 мэдээлэл, хугацаа хоцорч мэдээлсэн 21 мэдээлэл, байршуулаагүй 6 мэдээлэл байна. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний мэдээллийг байршуулахаас орлогын 923,642.6 мянган төгрөгийн 23 гүйлгээ, зарлагын 48,702.0 мянган төгрөгийн 5 гүйлгээ хугацаа хоцорч, орлогын 34,949.0 мянган төгрөгийн 6 гүйлгээ байршуулаагүй. Мөн худалдан авах ажиллагааны тайлан, санхүүгийн аудитын дүгнэлтийн мөрөөр авч хэрэгжүүлсэн ажлын тайлан, болон шилэн дансны мэдээлэл, зарлагын гүйлгээ бүрд түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэр эх хуулбарыг тус тус байршуулаагүй байна.	1	1,627,888.0			1	1,627,888.0		
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>1,627,888.0</b>			<b>1</b>	<b>1,627,888.0</b>		
<b>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</b>								
<b>Дүн</b>								
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>1,627,888.0</b>			<b>1</b>	<b>1,627,888.0</b>		



ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 12 өдөр

Дугаар 37-20810579-ТӨА-2026/008/НА-СТА-ТШЗ

Зуунмод сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төв аймгийн Сүмбэр сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төв аймгийн Сүмбэр сумын Эрүүл мэндийн төв нь тайлант онд нийт 171 мэдээлэл байршуулахаас хугацаандаа мэдээлсэн 144 мэдээлэл, хугацаа хоцорч мэдээлсэн 21 мэдээлэл, байршуулаагүй 6 мэдээлэл байна. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний мэдээллийг байршуулахаас орлогын 923,642.6 мянган төгрөгийн 23 гүйлгээ, зарлагын 48,702.0 мянган төгрөгийн 5 гүйлгээ хугацаа хоцорч, орлогын 34,949.0 мянган төгрөгийн 6 гүйлгээ, худалдан авах ажиллагааны тайлан, санхүүгийн аудитын дүгнэлтийн мөрөөр авч хэрэгжүүлсэн ажлын тайлан, шилэн дансны мэдээлэл, зарлагын гүйлгээ бүрд түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэр эх хуулбарыг тус тус байршуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 "хариуцлагатай байх", Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", 6.10-т "Шилэн дансны мэдээлэл, зарлагын гүйлгээ бүрд түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэрийн эх хуулбар, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг хавсаргасан байна" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10-т "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь үнэн зөв байршуулах зөрчлийг давтан гаргахгүй байх, биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газар-т ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төв аймгийн Сүмбэр сумын Эрүүл мэндийн төвийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Бат-Эрдэнэ, нягтлан бодогч Ж.Молор нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.ХИШИГЖАРГАЛ

УВАА УУЛ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ч.МӨНХТУЯА



ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 12 өдөр

Дугаар 37-20810579-ТӨА-2026/008/НА-СТА-ТШЗ

Зуунмод сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төв аймгийн Сүмбэр сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төв аймгийн Сүмбэр сумын Эрүүл мэндийн төв нь тайлант онд нийт 171 мэдээлэл байршуулахаас хугацаандаа мэдээлсэн 144 мэдээлэл, хугацаа хоцорч мэдээлсэн 21 мэдээлэл, байршуулаагүй 6 мэдээлэл байна. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний мэдээллийг байршуулахаас орлогын 923,642.6 мянган төгрөгийн 23 гүйлгээ, зарлагын 48,702.0 мянган төгрөгийн 5 гүйлгээ хугацаа хоцорч, орлогын 34,949.0 мянган төгрөгийн 6 гүйлгээ, худалдан авах ажиллагааны тайлан, санхүүгийн аудитын дүгнэлтийн мөрөөр авч хэрэгжүүлсэн ажлын тайлан, шилэн дансны мэдээлэл, зарлагын гүйлгээ бүрд түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэр эх хуулбарыг тус тус байршуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 "хариуцлагатай байх", Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", 6.10-т "Шилэн дансны мэдээлэл, зарлагын гүйлгээ бүрд түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэрийн эх хуулбар, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг хавсаргасан байна" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10-т "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь үнэн зөв байршуулах зөрчлийг давтан гаргахгүй байх, биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газар-т ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төв аймгийн Сүмбэр сумын Эрүүл мэндийн төвийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Бат-Эрдэнэ, нягтлан бодогч Ж.Молор нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.ХИШИГЖАРГАЛ

УВАА УУЛ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ч.МӨНХТУЯА



ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 12 өдөр

Дугаар 38-20810579-ТӨА-2026/008/НА-СТА-ТШЗ Зуунмод сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төв аймгийн Сүмбэр сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант оны эцэст 6,670,321 (зургаан сая зургаан зуун далан мянга гурван зуун хорин нэгэн) төгрөгийн өглөгтэй тайлагнасан харилцагч байгууллагуудтай өр төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.7-т “авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй”-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өр төлбөрийг тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх, биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газар-т ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төв аймгийн Сүмбэр сумын Эрүүл мэндийн төвийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Бат-Эрдэнэ, нягтлан бодогч Ж.Молор нарт даалгав.



АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

УВАА УУЛ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.ХИШИГЖАРГАЛ

Ч.МӨНХТУЯА

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум  
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр  
Утас: +976 70272582, +976 70273204  
И –мэйл: [tuv@audit.gov.mn](mailto:tuv@audit.gov.mn), Вебсайт: [www.audit.mn](http://www.audit.mn)